



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 5/18

Ховд

Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Х.Ганболдын хариуцаж байсан албан үүргийг түүний чөлөөтэй байх хугацаанд Энхтайваны Сүхтулгад 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2.Э.Сүхтулгад Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-5-ын 1 дэхь шатлалын 594803 төгрөг /Таван зуун ерөн дөрвөн мянга найман зуун гурван/-ийн цалинг тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, аж ахуйн тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД